



**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/584

Есөнбулаг

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийг судлах музейн сан хөмрөгийг шинэ байранд нүүлгэн шилжүүлэх зөөж, тээвэрлэх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж боловсруулах, нүүлгэн шилжүүлэх ажлыг гардан зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	С.Мөнхжаргал	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Гишүүд:	С.Цагаанбаатар	(аймгийн Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
	Т.Баярзул	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол, соёл хариуцсан мэргэжилтэн)
	И.Гантулга	(“Нийтлэг үйлчилгээ” УТҮГ-ын дарга)
	Д.Пүрэвням	(Тагнуулын ерөнхий газрын аймаг дах Тагнуулын хэлтсийн ажилтан)
	Д.Сүрэн	(Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч)
	Э.Өлзийдэлгэр	(Соёл, урлагийн газрын соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга:	Ш.Насан	(аймгийн Орон нутгийг судлах музейн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Сан хөмрөгийг нүүлгэн шилжүүлэх, зөөж тээвэрлэх ажлыг төлөвлөгөөний дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийж гүйцэтгэхийг ажлын хэсгийн ахлагч (С.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

